



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 11 сарын 19 өдөр

Дугаар А/Ан

Булган сум

Согтуурах, мансуурах донтой хүмүүсийг
албадан эмчилгээнд хамруулахад
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Согтуурах мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэг, Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.4 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2021 оны III/03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Согтуурах, мансуурах донтой хүмүүсийг албадан эмчилгээнд хамруулах арга хэмжээнд хавсралтад заасны дагуу 1,400,000 (нэг сая дөрвөн зуун мянга) төгрөг зарцуулсугай.

2. Албадан эмчилгээнд хамруулахтай холбогдох арга хэмжээ буюу шүүхийн шийдвэр гарахаас өмнөх шатанд гарах байр, хоолны зардлыг аймгийн Засаг даргын 2024 оны А/633 дугаар захирамжаар баталснаар "Зөв дадал-Архигүй орчин" хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (Б.Одхүү), Цагдаагийн газар (Цагдаагийн дэд хурандаа Г.Ганбаяр)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Д. ПҮРЭВ-ОЧИР



Сугар Ажил 2024 өдөр бүр Doc/2024/Захирамж

6324011079

Аймгийн Засаг даргын 2024 оны
... дүгээр сарын ...-ны/ний өдрийн ... дугаар
захирамжийн хавсралт



СОГТУУРАХ, МАНСУУРАХ ДОНТОЙ ХҮНИЙГ АЛБАДАН
ЭМЧЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДАЛ

д/д	Хүний тоо	Зардлын зориулалт	Зардлын хэмжээ /төгрөгөөр/	Тайлбар
1	2	3	4	5
1	14	14 хүний 2 хоногийн байрны зардал	12x300,0x2 хоног = 600,0	Bulgan hotel зочид буудалд 1 давхрын тус бүр 4 ортой 3 өрөөг тусгаарлан 14 хүнийг Лхагва, Пүрэв гарагт нийт 2 хоног байрлуулна.
2	14	2 хоногийн хоолны зардал	14x28,555x2 хоног = 799,4	
Дүн			1,400,000	Албадан эмчилгээнд хамрагдах хүмүүст өглөөний цай, өдрийн хоол, оройн хоолоор үйлчилнэ.